



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 25 өдөр

Дугаар 401

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бүгд Найрамдах Энэтхэг Улс дахь Монгол Улсын Элчин сайдын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, нийт 16,633.02 (арван зургаан мянга зургаан зуун гучин гурван ам.доллар хоёр цент) ам.долларын балансын үнэ, 16,624.13 (арван зургаан мянга зургаан зуун хорин дөрвөн ам.доллар арван гурван цент) ам.долларын хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Бүгд Найрамдах Энэтхэг Улс дахь Монгол Улсын Элчин сайд Г.Ганболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэг, материал болгон ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн
40/ дугаар тогтоолын хавсралт

**БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС ДАХЬ МОНГОЛ УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМНЫ
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон он	Хэм- жих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ (ам.долл)	Хуримтлагдсан элэгдэл (ам.долл)	Үлдэгдэл өртөг (ам.долл)
1	Агаар хөргөгч LG 1.5 тн	2011	ш	8	655.00	5,240.00	5,240.00	0.00
2	Агаар хөргөгч LG 1.5 тн	2011	ш	8	558.35	4,466.80	4,466.80	0.00
3	Агаар хөргөгч LG 1.5 тн	2011	ш	5	760.40	3,802.00	3,802.00	0.00
4	Агаар хөргөгч LG 1.5 тн	2011	ш	1	370.45	370.45	370.45	0.00
5	Агаар хөргөгч LG 1.5 тн	2010	ш	1	612.00	612.00	612.00	0.00
6	Компьютер	2012	ш	1	1,000.00	1,000.00	1,000.00	0.00
7	Принтер	2012	ш			0.00		0.00
8	Халаагуур(жихиг)	2013	ш	2	36.04	72.09	72.09	0.00
9	Машин угаах компрессор	2013	ш	1	163.93	163.93	155.04	8.89
10	Коридорын хивс	2011	ш	1	62.00	62.00	62.00	0.00
11	Хивс	2011	ш	2	64.00	128.00	128.00	0.00
12	Ipad	2012	ш	1	620.75	620.75	620.75	0.00
13	DVD тоглуулагч	2007	ш	1	95.00	95.00	95.00	0.00
	Дүн					16,633.02	16,624.13	8.89
						(арван зургаан мянга зургаан зуун гучин гурван ам.доллар хоёр цент)	(арван зургаан мянга зургаан зуун хорин дөрвөн ам.доллар арван гурван цент)	(найман доллар наян есөн цент)